



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

**Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх
Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.14, 96.5 дахь заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.7 дахь заалт, 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг тус тус зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.БОЛДСАЙХАН



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6, 7.10, 7.16, 7.18 дахь заалт, 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдээс кумулятив аргаар хамгийн олон санал авсан Н.Туул, С.Цолмон, Н.Данзандагва нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр, Ц.Баяр-Эрдэнэ, Д.Нарангэрэл, Б.Төрбат, Б.Билэгдэмбэрэл, А.Молор, С.Ганзориг нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс тус тус сонгосугай.

2. Х.Баянбайг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний үүрэгт ажлаас 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлж, бүрэн эрхийг нь дуусгавар болгосугай.

3. Компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм, журмын дагуу ажиллахыг сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.БОЛДСАЙХАН



МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6 дахь заалт, 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, зардал хэтрүүлэхгүй, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалинг түүний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгосугай.


ХУРЛЫН ДАРГА



Г.БОЛДСАЙХАН



Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2026 оны
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
03 дугаар тогтоолын Хавсралт.



ТУЗ-ИЙН 2026 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

/Нэгж: төгрөг/

№	Зардлын төрөл	Тоо	Нэгж зардал	Давтамж	Нийт дүн
	1. Цалингийн зардал				
1	ТУЗ-ийн дарга	1	1,400,000	12	16,800,000
2	ТУЗ-ийн хараат бус гишүүн	3	1,320,000	12	47,520,000
3	ТУЗ-ийн ердийн гишүүний цалин	5	1,200,000	12	72,000,000
4	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	1	1,200,000	12	14,400,000
	Цалингийн зардлын дүн				150,720,000
5	Нийгмийн даатгалын шимтгэл				20,045,760
	Дэд дүн				170,765,760
	2. Бичиг хэрэг, хурал, холбоо, тээврийн зардал				
1	Бичиг хэрэг, хэвлэмэл материал, цай, кофены зардал	1	180,000	12	2,160,000
2	Хурал зохион байгуулах байрны түрээс	1	200,000	2	400,000
3	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын холбоо, тээврийн зардал	1	180,000	12	2,160,000
4	Бусад зардал	1	100,000	5	500,000
	Дэд дүн				5,220,000
	3. Сургалт, компанийн салбар, нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцах зардал				
1	Сургалт, семинарын зардал				8,500,000
2	Томилолтын зардал				10,000,000
	Дэд дүн				18,500,000
	НИЙТ ДҮН				194,485,760

Тайлбар: Төсөв 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараа (2027) оны
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл хугацаанд хамаарна.